



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/101

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 03 сарын 16 ны өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргээ тогтвортой өсгөж, мал аж ахуйн салбарт амжилт гаргасан Улсын аварга малчин, аймгийн алдарт уяач, аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрх, аварга саальчин, аварга тариаланч хамт олон, тариаланч, улсын аварга малчин, ногоочноор шалгарсан нэр бүхий хүмүүсийн шагналд зарцуулсан хөрөнгийн үлдэгдэлд 1,642,000 (Нэг сая зургаан зуун дөчин хоёр мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 1,642,000 (Нэг сая зургаан зуун дөчин хоёр мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгийн газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.



ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН